



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/55

Хэрлэн сум

Өвс, тэжээлийн үнэ тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсөгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зохицуулалтын нийтлэг журмын 2.1.3, аймгийн Онцгой комиссын 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нөөцөд 2020 онд бэлтгэсэн 3850 боодол өнжсөн “Өвс”-ийг 1 боодлыг 3500 төгрөгөөр, мөн 2021 онд бэлтгэсэн “Өвс”-ийг 8000 төгрөгөөр, “Ногоон тэжээл”-ийг 1 боодлыг 7500 төгрөгөөр тус тус худалдан борлуулсугай.
2. Өвс, тэжээлийг тогтоосон үнээр худалдан борлуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Г.Лхагвахатан)-д үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010213